



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид хуралдлаа

2015 оны 4-р сарын 15-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.



1. Увс нуурын дэргэдэх аялал жуулчлалын баазыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлах журам, гэрээ, зар мэдээ, тогтоолын төсөл батлах
2. Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын /Битүү зах/-ын мэдээлэл
3. Орон нутгийн өмчийн илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгө худалдах, актлах тухай тогтоолын төсөл
4. Шагналд тодорхойлох тухай тогтоолын төсөл

Амьдрах ухаан боловсролын танхимтай боллоо

2015 оны 04 сарын 02-ны өдөр “Улаангом политехник коллеж”-д амьдрах ухаан боловсролын танхимын нээлт, тууз хайчлах ёслолын арга хэмжээ боллоо. Нээлтийн арга хэмжээнд Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, НҮБ-ын хүн амын сангийн төлөөлөгч Уянга, Аймгийн боловсролын газрын удирдлага болон “Улаангом политехник коллеж”-ийн захирал Ч.Наранбилэг нар оролцлоо. Уг танхим нь Швейцарийн хөгжлийн агентлаг, Монгол улсын засгийн газар, НҮБ-ын хүн амын сан, Люксембургийн засгийн газрын санхүүжилтээр хийгдэж байгаа залуучуудын хөгжлийн төсөл (2013-2017) -ийн хүрээнд хийгдэж буй томоохон ажлын нэг юм.



Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг даргын орлогч Б.Цэцээ, Улаангом сумын засаг дарга О.Ганхуяг, орлогч дарга Б.Гомбосүрэн, ГХБХБГ-ын дарга Г.Отгонболд, Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газрын дарга Ё.Мөнхзул нар Аймгийн төв замын дагуух байгууллага, албан газар, айл өрх, үйлчилгээний цэгүүдийн гадна тохижилт, пасаад, цэцэрлэгжүүлэлтийн талаар газар дээр нь үзэж танилцан холбогдох дарга болон иргэдтэй уулзаж ямар арга хэмжээ авах талаар үүрэг даалгавар өгч ажиллалаа. Мөн наадмын талбайн барилгын ажилтай газар дээр нь очиж танилцлаа. Төв зам дагуух болон орон сууцны хороолол дахь модон амбаар, грашнуудыг цэгцлэх, зам дагуух айлуудын хашаа хороог нэг стандартад оруулах талаар Улаангом сумын удирдлага болон ХХЦГ-т үүрэг даалгавар өглөө.

90 жилийн ойн бэлтгэл

2015 оны 04 сарын 13-ны өдөр Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг даргын орлогч Б.Цэцээ, Улаангом сумын засаг дарга О.Ганхуяг, орлогч дарга Б.Гомбосүрэн, ГХБХБГ-ын дарга Г.Отгонболд, Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газрын дарга Ё.Мөнхзул нар Аймгийн төв замын дагуух байгууллага, албан газар, айл өрх, үйлчилгээний цэгүүдийн гадна тохижилт, пасаад, цэцэрлэгжүүлэлтийн талаар газар дээр нь үзэж танилцан холбогдох дарга болон иргэдтэй уулзаж ямар арга хэмжээ авах талаар үүрэг даалгавар өгч ажиллалаа. Мөн наадмын талбайн барилгын ажилтай газар дээр нь очиж танилцлаа. Төв зам дагуух болон орон сууцны хороолол дахь модон амбаар, грашнуудыг цэгцлэх, зам дагуух айлуудын хашаа хороог нэг стандартад оруулах талаар Улаангом сумын удирдлага болон ХХЦГ-т үүрэг даалгавар өглөө.



Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг даргын орлогч Б.Цэцээ, Улаангом сумын засаг дарга О.Ганхуяг, орлогч дарга Б.Гомбосүрэн, ГХБХБГ-ын дарга Г.Отгонболд, Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газрын дарга Ё.Мөнхзул нар Аймгийн төв замын дагуух байгууллага, албан газар, айл өрх, үйлчилгээний цэгүүдийн гадна тохижилт, пасаад, цэцэрлэгжүүлэлтийн талаар газар дээр нь үзэж танилцан холбогдох дарга болон иргэдтэй уулзаж ямар арга хэмжээ авах талаар үүрэг даалгавар өгч ажиллалаа. Мөн наадмын талбайн барилгын ажилтай газар дээр нь очиж танилцлаа. Төв зам дагуух болон орон сууцны хороолол дахь модон амбаар, грашнуудыг цэгцлэх, зам дагуух айлуудын хашаа хороог нэг стандартад оруулах талаар Улаангом сумын удирдлага болон ХХЦГ-т үүрэг даалгавар өглөө.

Жудо бөхийн өсвөрийн улсын аваргын тэмцээн болж өнгөрлөө

Монгол улсын гагьяат тамирчин, ардын багш, Жудо бөхийн дэлхийн аваргын мөнгөн медальт, Монгол улсын аварга О.Балжиннямын нэрэмжит Жудо бөхийн өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээн



Увс аймгийн Улаангом хотноо амжилттай болж дүнгээ гаргалаа. Тэмцээнд 40 байгууллагын 72 багийн 600 гаруй тамирчид оролцож гурван өдрийн турш уран мэх, хурд хүчийг уралдуулан өрсөлдлөө. Тэмцээнд Увс аймгийн шигшээ баг нийт 1 алт, 1 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж, охидын шигшээ багийн тамирчид багаараа хүрэл медаль хүртсэн бахдам сайхан амжилт үзүүлээ.

Хувийн хэвшлийнхэн санал солилцлоо

Увс аймаг ирэх 6-р сарын 25,26-нд зохион байгуулах олон улсын хөрөнгө оруулалтын чуулгантай холбогдуулан аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг даргын орлогч Б.Цэцээ, ХБХ-ийн дарга З.Ганболд нар хувийн хэвшлийн төлөөлөлтэй уулзлаа. 90 гаруй аж ахуйн нэгжийн дарга эрхлэгч нартай утсаар холбогдож, нэг бүрчлэн зар түгээсэн ч уулзалтад 20 орчим аж ахуйн нэгжийн төлөөлөл ирлээ. Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд хэлэхдээ “Та бүхэнтэй уулзах гол зорилго нь хөрөнгө оруулалтын чуулганд төрийн ямар байгууллагын төлөөллийг урих, та бүхний харилцааг, харилцаа тогтоох гэж буй гадаад дотоод түншүүдээс хэнийг нь урих талаар саналыг тань сонсож байна. Түүнчлэн Увс аймаг эдийн засгийн хөгжлийн бодлогоо батлан гаргасан. Их наядын эдийн засагтай болоход хувийн хэвшлийнхэн манлайлна. Хүлээгдэж буй олон төслүүд бий. Тэдгээрийг хэрэгжүүлэх талаар санаа, оноогоо хуваалцаж, төрийн бодлогоо дэмжиж, хэрэгжүүлж ажиллахыг хүслээ.” Харин аймгийн Засаг даргын орлогч Б.Цэцээ: “Бид хувийн хэвшлийнхэнтэй тогтмол уулзах цагаа зарласан. Сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн даваа гарагийн 13 цагаас уулзаж байгаа. Уулзалтад ирж байгаа байгаа байгууллагуудын идэвх сул байна. Бид та бүхэнтэй ярилцаж, санаа оноог чинь сонсож ажиллахыг хүсч байна. Аливаад ажил хэрэгч хандая” гэсэн саналыг хэлсэн юм.



Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг даргын орлогч Б.Цэцээ, Улаангом сумын засаг дарга О.Ганхуяг, орлогч дарга Б.Гомбосүрэн, ГХБХБГ-ын дарга Г.Отгонболд, Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газрын дарга Ё.Мөнхзул нар Аймгийн төв замын дагуух байгууллага, албан газар, айл өрх, үйлчилгээний цэгүүдийн гадна тохижилт, пасаад, цэцэрлэгжүүлэлтийн талаар газар дээр нь үзэж танилцан холбогдох дарга болон иргэдтэй уулзаж ямар арга хэмжээ авах талаар үүрэг даалгавар өгч ажиллалаа. Мөн наадмын талбайн барилгын ажилтай газар дээр нь очиж танилцлаа. Төв зам дагуух болон орон сууцны хороолол дахь модон амбаар, грашнуудыг цэгцлэх, зам дагуух айлуудын хашаа хороог нэг стандартад оруулах талаар Улаангом сумын удирдлага болон ХХЦГ-т үүрэг даалгавар өглөө.



2015 оны 04-р сар

Зүүнговь сум:

Тохой багт хилийн цэргийн 0314-р ангийн бүрэлдэхүүнтэй хамтран хил хамгаалахад туслах хүчнийхэн болон хил орчмын бүсийн оршин суугчидтай уулзалт өдөрлөг зохион байгуулж, хилчид болон малчдын санал хүсэлтийг сонсон хамтран ажиллаж амьдрах талаар ярилцлага зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр хилийн цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчид хилчид, хилийн бүсэд оршин суугчдад урлагийн тоглолт хийлээ.

Баруунтуруун сум:



2015 оны 4-р сарын 03ны

өдрийн 09.00 цагт Баруунтуруун сумын Иргэний танхимд "Орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоо – Нийгмийн хариуцлага" сэдэвт зөвлөгөөн хэлэлцүүлэг боллоо. Зөвлөгөөнөөр орчны бохирдолын төлөв, одоогийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар сумын Байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн С.Лхагвасүрэнгийн мэдээллийг хэлэлцэв.

Зөвлөгөөнд сумын удирдлага байгууллага аж ахуй нэгжийн дарга эрхлэгч, иргэдийн болон хүүхдийн төлөөлөл болсон 40 гаруй хүн оролцлоо. Зөвлөгөөнөөс орчны бохирдолыг бууруулахад иргэн байгууллага, хүүхдүүдийн оролцоог тодорхойлсон 5 зөвлөмж гаргаж оролцогчдод гарын авлага болгон өглөө. Зөвлөгөөнд оролцогчид, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн санал дүгнэлтийг тусган Орчны бохирдолыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай Засаг даргын А/24 тоот захирамж гаргав.

Газар тариалан, жимс жимсгэнэ эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн болов

2015 оны аймгийн газар тариалан, жимс жимсгэнэ эрхлэгчдийн зөвлөгөөн Баруунтуруун суманд 04-р сарын 20 - ны өдөр боллоо.



Энэхүү зөвлөгөөнд аймгийн газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн томоохон төлөөлөгчид болон тус салбарын төрөлжсөн холбоодын дарга, тэргүүлэгчид, сумын МЭҮТ-ийн холбогдох мэргэжилтнүүд аймгийн удирдлага, ХХАА-н газрын мэргэжилтнүүд, холбогдох агентлагийн дарга, мэргэжилтэн нар оролцлоо.

Үүнд: Аймгийн Засаг дарга Д.Цэндсүрэн, орлогч дарга Б.Цэцгээ, аймгийн ХХАА-н газрын дарга Ж.Александр, МХГ-ын үр, ургамлын хорио цээрийн улсын байцаагч Г.Нямжав, УЦУОШГ-ын ГХБХБГ-ын ахлах мэргэжилтэн Б.Даалхай, Н.Ганчимэг ББЭШХ-н агрономич Л.Алтай, сумдын Засаг дарга нар, мэргэжилтэн, тариаланчдын төлөөлөл зэрэг 120 гаруй хүн хамрагдлаа.

Өмнөговь сум:



1. "Хүүхдийн индэр" байгуулж гэмт хэрэг, зөрчлийн талаар хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдийн

эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх асуудлаар 6-11 дугаар ангийн нийт 15 хүүхдийг хамруулсан хэлэлцүүлгийг 4-р сарын 23-д зохион байгуулсан.

2. СГХУСА33-ийн ажлын календарчилсан төлөвлөгөө гаргаж дэд зөвлөлүүдэд ажил үүргийг хувиарлав.

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэгийг 4-р сарын 16-нд гарган нийт 147 өрхөд тараалаа.

4. Сумын ИТХ-ын ээлжит бус 7-р хуралдааныг 4-р сарын 15-ны өдөр хуралдууллаа.

5. Сумын ИТХ-ын 37-р тойрогт нөхөн сонгуулийн ажлыг 4-р сарын 24-ны өдөр зохион байгуулан явуулж дүн мэдээг хүргүүлсэн.

6. "Буман хонь" хөтөлбөрийг 2015-2020 он хүртэл хэрэгжүүлэхээр баталсан нь малын чанар, ашиг шимийг сайжруулах талаар хэлэлцсэн, малчид руу хандсан томоохон баримт бичиг гаргалаа.

7. Сумын 2008-2016 он хүртлэх хөгжлийн стратеги төлөвлөгөө 83%-тай хэрэгжсэн гэж дүгнэж шинээр 41 заалт нэмж оруулан 2020 он хүртэл хэрэгжүүлэхээр баталлаа.

8. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураглалын төсөл гаргаж иргэд, хурлын төлөөлөгчдийн дунд хэлэлцүүлэг явуулж зураглалын эхийг баталлаа.

Сагил сум:

Сагил сумын ИТХ-ын дарга Д.Дэлгэрхишиг ОХУ-ын Тува улсын Өвөрхошууны Сагли-Улаантуг тосгоны дарга Алисей



Ичинноровтой Сагилийн голын эхний байгаль орчныг хамгаалах тухай санамж бичигт гарын үсэг зурлаа.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uvs.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

www.facebook.com/groups/uvs.ith